



ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Улс төрийн үйл ажиллагаа
2. Намын хурал, дотоод сонгууль, ил тод байдал
3. Гишүүдийн хөгжил
4. Гадаад харилцаа

Нэг. Улс төрийн үйл ажиллагаа.

ИОНН 2023 онд парламентын гаднах сөрөг хүчний үүрэгтэйгээр улс төрийн үйл ажиллагаа явуулж, иргэдийнхээ Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хадгалахад чухал хувь нэмэр оруулж чадлаа. Тухайлбал,

- “Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт” жагсаал зохион байгуулан хүүхдийн мөнгийг 10 хүүхэд тутмын нэгээс статистикийн аргаар хасахыг эсэргүүцэж УИХ, Засгийн газарт шаардлага хүргүүлэн, ИОНН-ын гишүүд Үндсэн хуулийн цэцэд хандав. Энэ талаар хэвлэл мэдээллээр идэвхитэй дуу хоолойгоо үргэлжлүүлэн хүргэсэн ба Үндсэн хуулийн цэц хүүхдийн мөнгөний асуудлаар хуралдаан хийхээр болов. Гэвч уг хуралдаанаас өмнө УИХурал өмнөх шийдвэрээ залруулсан бөгөөд 2023 оны 7-р сараас эхлэн хүүхдийн мөнгө олгож, өмнөх саруудынхыг мөн нөхөн олголоо.
- 2023 оны 1 сарын 18-20-ны өдрүүдэд УИХ дээр хэлэлцүүлэн яаралтай горимоор баталсан “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай” хуулийг ИОНН хүчтэй эсэргүүцэж Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд огцрох шаардлага хүргүүлэв. Мөн олон нийтийн сүлжээгээр ИОНН-ын гишүүд уг хуулийг эсэргүүцэн дуу хоолойгоо идэвхитэй өргөв. Үүний үр дүнд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ЗГ-ын төслөөр батлагдсан хуулинд бүхэлд нь хориг тавьж, УИХ уг хоригийг хүлээн авав.
- 2023 оны 2 дугаар сарын эхнээс 5 дугаар сарыг дуустал дөрвөн сарын хугацаанд Монгол Улсын 1992 оны ардчилсан Үндсэн хуульд аюул занал учирсан билээ. “Үндсэн хуулийг шинэчилж найруулах” хэмээх Үндсэн хуульд байхгүй нэр томъёогоор төлөөллийн ардчилалын санал асуулга УИХ-ын зохион байгуулалтаар явагдсан бөгөөд энэ асуулгын үр дүн хүссэнээр нь гарсан тохиолдолд 1992 оны ардчилсан үндсэн хуулийг бүхэлд нь хүчингүй болгох үр дагавар бүхий “шинэчилж найруулсан” Үндсэн хуулийг МАН-ын дарга, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг бэлэн болгож дипломат төлөөлөгчид, хэвлэл мэдээллийнхэнд ном болгон хэвлэн тараасан байлаа. Иргэдийн Оролцооны Нэгдэл нам дөрвөн сарын турш ардчилсан үндсэн хуулийнхаа манаанд зогссон цорын ганц улс төрийн нам байж чадлаа. Учир нь парламентад суудалтай болон суудалгүй бусад бүх улс төрийн нам “Үндсэн хуулийг шинэчилж найруулах” хэмээх үйл ажиллагааг нэгэн дуугаар дэмжиж байв.

Гэвч Монголын олон нийт ИОНН-ын байр суурийг тууштай дэмжив. Олон нийтийн тууштай дэмжлэгийн үр дүнд ИОНН-ын тавьж байсан шаардлагууд биелж, ардчилсан Үндсэн хууль хэвээр үлдэж чадав. Ардчилсан Үндсэн хуулиа авч үлдэж чадсан нь ИОНН-ын 2023 онд гүйцэтгэж чадсан улс төрийн хамгийн том үүрэг байлаа.

- Ардчилсан Үндсэн хуулиа авч үлдэж чадсанаар:

- a. Ой, ус, ан амьтан төрийн өмч хэвээр үлдэв.
 - b. Парламентад цөөхөн эрхтэн дархтан шууд томилогдож орж ирэхийг зогсоож, бүх гишүүд иргэдээс сонгогддог зарчим хэвээр үлдэв
 - c. Газар, бэлчээр, байгалийн баялаг ганц хүний гарт төвлөрөхөөс хамгаалж чадав. Сум, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлыг хэвээр авч үлдэв.
 - d. Төрийн өндөр албан тушаалтны эсрэг үндсэн хуулийн цэцэд иргэн гомдол гаргах эрхийг авч үлдэж чадав.
 - e. УИХ –д 152 гишүүнтэй болох гэсэн санаархлыг эсэргүүцэж бууруулав.
- Хотын төвөөр 27500 төгрөг төлж зорчих тухай хуулийг эсэргүүцэж, хотын төвийн бүсийн татварыг хуулинаас хасуулахад нөлөөлж чадав.
 - 2023 оны 6 сард болсон орон нутгийн нөхөн сонгуульд Сүхбаатар дүүрэг, Баянгол дүүрэг, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд тус тус нэр дэвшүүлэлтийг эхлүүлэв. Сүхбаатар дүүрэгт ИОНН-ын материалыг хүлээн авахаас татгалзан буцаав. Баянгол дүүрэгт Сонгуулийн хороо нь даргагүй болж, материал хүлээн авах эзэнгүйдэлт үүсэн, нөхөн сонгуулийг зохион байгуулахгүй орхигдуулсан болно. Харин Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд ИОНН-аас Батбаатарын Ууганбаярыг нэр дэвшигчээр бүртгэн авав. Ингэснээр ИОНН анхныхаа сонгуульд Өвөрхангай аймагт өрсөлдлөө. Тус тойрогт ердөө хоёр нам өрсөлдсөн бөгөөд МАН ялж, ИОНН-ын нэр дэвшигч 12 хувийн санал авав.

Хоёр. Намын хурал, дотоод сонгууль, ил тод байдал

- Намын ээлжит анхдугаар их хурал 2023 оны 3 сарын 30-ны өдөр хуралдав.
- ИОНН-ын 2023 оны 3-р сарын 30-нд болсон дотоод сонгуулиар Төлөөлөгчдийн Танхим, Үнэт зүйлийн зөвлөлд шинээр гишүүд сонгогдлоо.
- Дархан-Уул, Орхон аймгуудад Танхим байгуулагдаж танхимын дарга нар сонгогдов.
- Нийт 110 анхан шатны салбар байгуулагдаж, салбарын дарга, танхимын гишүүд сонгогдов.
- Төлөөлөгчдийн Танхим 10 удаа хуралдав. Төлөөлөгчдийн Танхим 2023 онд хоёр шинэ журам батлав. Үүнд:
 - ТТ-ын 2023 оны 5-р хурлаас “Иргэдийн Оролцооны Нэгдэл Намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлав.
 - ТТ-ын 2023 оны 6-р хурлаас “ИОНН-аас төрийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүдийн тандалт үнэлгээний тухай журам”-ыг батлав.
- Үнэт зүйлийн зөвлөл хоёр удаа хуралдаж тус бүрт улс төрийн мэдэгдэл гаргаж УИХ-ын дарга, Засгийн Газрын тэргүүнд хүргүүлжээ.
- Намын өдөр тутмын болон улс төрийн үйл ажиллагааг цахим орчинд дараах хаягаар мэдээлж ажиллав. Үүнд:
 - www.cup.mn
 - <https://www.facebook.com/civicunitypartyMN>
 - <https://www.instagram.com/civicunitypartymn/>
 - <https://twitter.com/civicunityparty>
- Намын гишүүдэд “Иргэний оролцоо” апп-аар дамжуулан зарыг хүргэж ирэв. Тус аппыг сайжруулан ИОНН апп болгож хөгжүүлэв.

- Намын дотоод үйл ажиллагаанд хоёр удаа дотоод аудитын хяналт тавиулав. Намын санхүүд 2 удаа хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулж ажиллав.
- 2023 онд намын дотоод үйл ажиллагааны зардал 29.8 сая төгрөг болов. Үүнийг намын гишүүдийн татвар, хандив болон эрх эзэмшигчийн орлогоос тус тус санхүүжүүллээ.

Гурав. Гишүүдийн хөгжил

- 2023 онд Намын гишүүдийн хөгжилд зориулж 1-5-р сар, 9-10-р сарын долоо хоног бүрийн Пүрэв гаригт сургалт зохион байгуулж ирлээ. Сургалтын хуваарь, сэдвийг гишүүдээр хэлэлцүүлэн зөвшилцөж гаргасан бөгөөд нийт 28 сургалтыг нээлттэй зохион байгууллаа.
- Гишүүдийн шинэ жилийн арга хэмжээг гишүүдийн идэвхитэй оролцоотойгоор 2023 оны 12 сарын 18-ны өдөр зохион байгуулав. Таксын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас бага буюу 25,000 төгрөгт багтаав.
- Намрын сургалтын нээлтийг 2023 оны 9 сарын 9-ний өдөр гэр хороололд зохион байгууллаа.

Дөрөв. Гадаад харилцаа

- Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам 2023 оны Германы Конрад Аденауэрийн Сангийн Монгол дах төлөөлөгчийн газартай хамтран ажиллав. КАС нь ИОНН-ын гишүүддээ нээлттэй хүргэдэг сургалтыг дэмжиж техникийн туслалцаа үзүүлэв.